

Ипотекийн зээлийн тайлан

2016 оны 5 дугаар сар

Банкууд 2016 оны 5 дугаар сард нийт 1654 зээлдэгчид 102.0 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгосноор ипотекийн зээлийн үлдэгдэл 3704.2 тэрбум төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 83280-д хүрчээ. Тайлант сард 5%-ийн хүүтэй 21.1 тэрбум төгрөгийн зээлийг 439 зээлдэгчдэд олгосон бол 8%-5% руу 9.2 тэрбум төгрөгийн, банкуудын өөрийн эх үүсвэрээс 5%-руу 2.1 тэрбум төгрөгийн зээлийг тус тус шилжүүлжээ.


Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хурд өмнөх сартай харьцуулахад 0.6 нэгж хувиар өссөн бол өмнөх оны мөн үеэс 13.8 нэгж хувиар буурч 18.4 хувьд хүрсэн байна.



Тайлант сарын эцэст ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.5 хувь буюу 2832.3 тэрбум төгрөгийг “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл (жилийн 5

болон 8 хувийн хүүтэй зээл, 5 болон 8 хувийн хүүтэй зээлд шилжүүлсэн зээл), 21.9 хувь буюу 809.8 тэрбум төгрөгийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, 1.7 хувь буюу 62.1 тэрбум төгрөгийг бусад эх үүсвэрээр олгосон зээл бүрдүүлж байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэл, эх үүсвэрээр



2016 оны 5 дугаар сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.0 хувь нь төгрөгийн зээл, 1.0 хувь нь валютын зээл байна.

Ипотекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2016 оны 5 дугаар сарын байдлаар 2.8 хувь, чанаргүй зээлийн эзлэх хувь 1.1 байна.



Тайлант сард олгосон зээл

Тухайн сард олгосон ипотекийн зээл өмнөх сараас 13.5 хувиар, өмнөх оны мөн үеэс 23.6 хувиар тус тус өсч 102.0 тэрбум төгрөгт хүрчээ.



Тайлант сард шинээр олгосон зээлийн 89.1 хувь буюу 90.9 тэрбум төгрөг нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээл, 10.9 хувь буюу 11.1 тэрбум төгрөг нь банкуудын өөрийн эх үүсвэрээс олгосон зээл байна.



Нэг зээлдэгчид ногдох олгосон зээлийн хэмжээ 2016 оны 5 дугаар сарын байдлаар 61.5 сая төгрөг байна.

Тухайн сард 30.4 тэрбум төгрөгийн ипотекийн зээл төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар буурчээ.



Зээлдэгчдийн тоо

Тайлант сард нийт 1654 зээлдэгч шинээр ипотекийн зээлд хамрагдсанаас 1409 зээлдэгч “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд, 245 зээлдэгч банкны өөрийн эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.




2016 оны 5 дугаар сарын байдлаар нийт 83280 иргэн ипотекийн зээлтэй байгаагаас 60455 нь “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр”-ийн зээлд (үүнээс 1154 нь 5 хувийн хүүтэй зээлд, 850 нь 8 хувиас 5 хувь руу шилжсэн зээлд хамрагджээ), 20942 нь банкуудын өөрийн эх үүсвэрийн зээлд, 1883 нь бусад эх үүсвэрийн зээлд хамрагдсан байна.



Зээлийн хугацаа


Тайлант сард банкууд 2.4 сараас 30 жилийн хугацаатай зээл олгосон бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 19.7 жил байна. Ипотекийн зээлийн үлдэгдлийн жигнэсэн дундаж хугацаа 2016 оны 5 дугаар сарын байдлаар 16.2 жил байна.

Тухайн сард олгосон зээлийн дийлэнх буюу 47.3 хувь нь 16-20 жилийн хугацаатайгаар олгогдсон байна. Харин нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн 71.9 хувь нь 16-20 жил, 17.0 хувь нь 11-15 жил, 9.1 хувь нь 6-10 жил, 1.1 хувь нь 1-5 жилийн хугацаатай байна.



Зээлийн хүү

Банкуудын 2016 оны 5 дугаар сард олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 8.3 хувь болжээ. “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр” хэрэгжиж эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад жигнэсэн дундаж хүү 8.3 нэгж хувиар буурсан байна.



Банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 16.3 хувь байв. Ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүү 6.7-10.4 хувийн хооронд байлаа.

Хавсралт 1. Банкуудын ипотекийн зээлийн тайлан

Он	Сар	Ипотекийн зээлийн үлдэгдэл (сая төг.)	Үүнээс:	Тайлант сард шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хугацаа (жилээр)	Тухайн сард олгосон зээлийн жилийн ЖДХүү, (%)	Нийт зээлдэгч (тоогоор)	Үүнээс:
			ОСИССТБ хөтөлбөрийн зээл				ОСИССТБ хөтөлбөрийн зээлтэй
2008	12	217,977.5		8.4	19.8	16,522	
2009	12	226,040.6		8.6	18.7	16,784	
2010	12	333,776.6		9.6	16.0	16,700	
2011	12	669,662.8		12.9	14.8	26,869	
2012	12	845,204.4		13.0	15.3	29,887	
2013	12	1,938,945.3	1,248,633.8	16.1	9.9	48,320	30,600
2014	1	2,021,424.9	1,324,898.9	16.2	9.8	49,731	32,190
	2	2,121,802.6	1,382,084.1	16.1	9.9	53,611	33,346
	3	2,193,368.6	1,451,938.1	15.9	9.9	54,787	34,632
	4	2,280,503.5	1,538,506.8	16.0	9.8	56,137	36,081
	5	2,365,349.5	1,618,127.2	15.8	10.0	57,579	37,488
	6	2,440,007.1	1,684,583.9	15.2	10.5	58,793	38,659
	7	2,492,105.2	1,728,222.8	15.7	10.7	59,756	39,507
	8	2,553,827.2	1,780,078.3	15.6	10.5	60,851	40,405
	9	2,619,161.1	1,833,494.0	15.5	10.6	62,017	41,390
	10	2,703,792.6	1,903,636.6	15.8	10.4	63,652	42,772
	11	2,762,726.8	1,954,341.3	16.2	10.3	64,577	43,621
	12	2,844,706.3	2,027,952.9	16.7	9.9	66,334	45,283
2015	1	2,898,731.0	2,072,894.5	16.3	10.2	67,233	46,134
	2	2,949,116.5	2,121,339.7	16.6	9.7	68,126	47,108
	3	3,015,535.1	2,196,795.5	16.5	9.2	69,269	48,512
	4	3,082,551.7	2,263,794.5	16.6	9.6	70,498	49,691
	5	3,128,182.4	2,305,308.1	16.4	10.3	71,355	50,462
	6	3,192,029.1	2,363,999.7	16.4	9.6	72,412	51,438
	7	3,230,507.8	2,400,625.2	16.1	9.9	73,208	52,181
	8	3,267,175.5	2,433,968.6	16.3	10.0	73,949	52,858
	9	3,319,711.8	2,481,556.8	16.2	9.6	74,848	53,643
	10	3,370,510.2	2,534,505.4	16.8	9.4	75,877	54,612
	11	3,412,929.6	2,570,150.9	16.4	10.0	76,583	55,295
	12	3,432,957.6	2,590,987.6	16.7	8.8	77,105	55,830
2016	1	3,434,849.9	2,595,234.1	16.3	10.1	77,226	56,031
	2	3,459,596.6	2,623,837.0	16.6	9.2	77,673	56,577
	3	3,565,321.5	2,679,829.3	17.1	8.8	81,015	57,659
	4	3,632,982.1	2,751,292.4	16.1	8.2	82,320	59,001
	5	3,704,168.2	2,832,261.7	16.2	8.3	83,280	60,455

Хавсралт 2. Орон нутгийн банкуудын ипотекийн зээлийн тайлан

2016 оны 5 дугаар сарын байдлаар

Аймгууд	Ипотекийн зээлийн		Үүнээс ОСИСТТБХ-ийн зээл		Тухайн сард олгосон ипотекийн зээлийн жилийн ЖДХугацаа	Тухайн сард олгосон ипотекийн зээлийн ЖДХүү (жилээр)	Нийт зээлдэгчдийн тоо	Үүнээс: ОСИСТТБ хөтөлбөрийн зээлтэй
	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь	Үлдэгдэл (сая төг.)	Эзлэх хувь				
1 Улаанбаатар	2,843,427.7	76.76	2,150,153.4	78.15	16.8	8.8	56486	42,289
2 Дархан-Уул	121,008.8	3.27	98,491.4	3.58	18.9	8.3	3499	3,003
3 Орхон	118,309.1	3.19	91,882.0	3.34	12.4	9.3	3036	2,576
4 Дорноговь	75,853.9	2.05	56,204.1	2.04	16.7	6.1	2185	1,710
5 Дорнод	55,010.8	1.49	44,568.2	1.62	17.3	5.0	1740	1,506
6 Сэлэнгэ	49,304.1	1.33	35,597.3	1.29	14.2	7.4	1693	1,114
7 Увс	48,872.4	1.32	30,059.5	1.09	17.6	6.6	1576	828
8 Өвөрхангай	46,202.2	1.25	29,759.3	1.08	17.6	6.5	1628	854
9 Өмнөговь	42,940.0	1.16	29,721.3	1.08	14.6	6.6	1173	826
10 Ховд	40,528.0	1.09	26,076.2	0.95	17.9	6.5	1312	946
11 Баянхонгор	31,262.3	0.84	21,366.9	0.78	19.6	5.9	951	694
12 Сүхбаатар	29,939.0	0.81	18,856.7	0.69	16.8	8.4	991	583
13 Архангай	28,151.3	0.76	18,268.7	0.66	17.7	6.3	818	531
14 Баян-Өлгий	24,695.3	0.67	10,710.1	0.39	18.3	5.8	1148	268
15 Говь-Алтай	22,209.0	0.60	15,642.1	0.57	18.0	9.9	711	499
16 Хөвсгөл	21,707.7	0.59	9,563.3	0.35	20.8	6.6	859	253
17 Завхан	21,571.2	0.58	11,661.8	0.42	13.4	7.1	780	328
18 Хэнтий	20,207.6	0.55	13,153.7	0.48	17.9	5.3	600	436
19 Төв	18,803.9	0.51	10,947.6	0.40	20.5	6.0	595	333
20 Дундговь	16,714.3	0.45	11,192.5	0.41	16.8	9.0	558	346
21 Булган	14,354.4	0.39	6,522.6	0.24	15.3	5.8	512	181
22 Говьсүмбэр	13,095.3	0.35	10,893.9	0.40	13.2	9.2	429	351
Нийт	3,704,168.2	100.00	2,751,292.4	100.00	16.7	8.8	83280	60455

2016 оны 2 дугаар сарын байдлаар банкуудын ипотекийн зээлийн үлдэгдлийн 76.8 хувийг Улаанбаатар хотод, 23.2 хувийг хөдөө орон нутагт олгосон ипотекийн зээл бүрдүүлжээ. Хөдөө орон нутаг дахь ипотекийн зээлийн үлдэгдлийн 14.1 хувь буюу 121.0 тэрбум төгрөг Дархан-Уул аймагт, 13.7 хувь буюу 118.3 тэрбум төгрөг Орхон аймагт, 8.8 хувь буюу 75.9 тэрбум төгрөг Дорноговь аймагт ногдож байна.